МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 26 өдөр Дугаар А/22 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.3, Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоол, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 14 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оныг "Хөвсгөлд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан тус арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд 17,052,778 (Арван долоон сая тавин хоёр мянга долоон зуун далан найман) төгрөг, өвлийн аялал жуулчлалын чиглэлээр контент бүтээхэд 9,500,000 (Есөн сая таван зуун мянган) төгрөг, олон нийтэд сурталчлахад 13,000,000 (Арван гурван сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардлын нийт 39,862,778 (гучин есөн сая найман зуун жаран хоёр мянга долоон зуун далан найман) төгрөгийг Засаг дарга дансны "Хөвсгөлд зочлох жил нэрлэсэн жилийн арга хэмжээний зардал"–аас гаргаж Байгаль орчин, аялал жуулчлалын газарт шилжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Хуваарилагдсан хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, зориулалтын дагуу зарцуулж, баримтын бүрдлийг ханган ажлын тайлан мэдээг 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн дотор танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671010202